



**ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2018 оны 12 сарын 24 өдөр

Дугаар А/812

Эрдэнэт

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 /а/, 29.1.6 /г/, 29,2, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн ээлжит IX хуралдааны 04 дүгээр тогтоолоор батлагдсан аймгийн эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Засаг даргын 2016 оны А/269 дүгээр захирамжаар батлагдсан “Оны шилдэг аж ахуйн нэгжийг шалгаруулах журам”-ын дагуу 2018 оны шилдэг аж ахуйн нэгжийг шалгаруулах үйл ажиллагааны зардалд шаардлагатай 10110000 /Арван сая нэг зуун арван мянган/ төгрөгийг хавсралтаар баталж 2017 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн ээлжит IX хуралдааны 04 дүгээр тогтоолын III хавсралтаар батлагдсан Засаг даргын төсөл хөтөлбөрийн зардлын “Эрдэнэтэд үйлдвэрлэв хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардал” -аас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэг/-т зөвшөөрсүгэй.

2.Захирамжийн хэрэгжилтийг ханган, дээрх үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс /н. Баяржаргал/-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Д.БАТЛУТ



Аймгийн Засаг даргын 2018 оны
12 дугаар сарын 27-ны өдрийн
А/812 дугаар захирамжийн хавсралт

ОНЫ ШИЛДЭГ 3 АЖ АХУЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГА
ШАЛГАРУУЛАХ ШАГНАЛЫН ТӨСӨВ

	Зардлын нэр	Тоо хэмжээ	Нэгж үнэ	Нийт үнэ
1	Цом	3	260000	780000
2	Өргөмжлөл	3	110000	330000
3	Мөнгөн шагнал	3	3000000	9000000
	Нийт дүн			10110000